

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд унаж, сүүлийн нэг жилийн хугацаан дахь хамгийн доод түвшинд хүрлээ. Газрын тосны үнэ огцом буурч, эрчим хүчний салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш унав. S&P 500 индексийн сагсанд багтдаг түүхий эд боловсруулагч компаниудын хувьцааны ханш хамгийн их өсөлттэй байлаа.

АНУ-ын Төв банк бодлогын хүүг энэ он гарснаас хойш дөрөв дэх удаагаа нэмэгдүүлэх шийдвэр гаргалаа. Энэ сарын 18-19-нд болсон Мөнгөний бодлогын зөвлөлийн уулзалтаар бодлогын хүүг 0.25 хувиар нэмэгдүүлж, 2.25-2.5 хувьд хүргэсэн байна. Үүний дараа хөрөнгийн зах зээлийн индексүүд огцом унаж эхлэв. Тус банк ирэх онд бодлогын хүүгээ гурав биш хоёр удаа нэмэгдүүлэх таамаг гаргажээ.

АНУ-ын Төлөөлөгчдийн танхим Дональд Трампын хилийн дагуу хэрэм барихад зориулсан таван тэрбум ам.долларын санхүүжилтийг төсөвт тусгах талаарх саналыг дэмжин баталлаа.

Европ: Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд буурлаа.

Итали улсын Засгийн газар Европын холбоотой тохиролцоонд хүрсэн талаар мэдээлж, тус улсын Засгийн газрын бондын өгөөж 2.94%-аас 2.74% болж буурсан бол Италийн банкуудын хувьцааны ханш өссөн үзүүлэлттэй байна. Ингэснээр Итали улсын 2019 оны төсвийн алдагдал тус улсын ДНБ-ий 2.0%-тай тэнцэх болжээ.

"Ifo" институтээс гаргадаг Германы бизнесийн итгэлийн индекс 4 сарын турш буурсны эцэст өнгөрсөн сард сүүлийн 2 жилийн хамгийн доод түвшинд хүрлээ. Энэ нь тус улсын эдийн засгийн өсөлт удааширч байгаа талаар дохио өгч байна хэмээн шинжээчид үзэж байна.

11-р сард Франц улсын хэрэглээний зардал буурч, 3-р улирлын эдийн засгийн үзүүлэлтүүд таамаг хэмжээнд хүрч чадаагүй аж. Мөн 12-р сард Франц улсын үйлдвэрлэгчдийн итгэлийн индекс буурсан талаар Францын Үндэсний эдийн засаг, статистикийн хүрээлэн мэдээлэв.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн Nikkei 225 индекс бусад улсын зэх зээлийн индексүүдийн адил унасан байна.

'Softbank Group' болон 'Sony' компаниудын хувьцааны ханш 9 орчим хувиар буурчээ. Япон улсын түүхэн дэх хамгийн том IPO-д тооцогдох 'Softbank Group' компанийн хувьцааны ханш арилжааны эхний өдрөө унасан байна.

БНХАУ: Хятадын Засгийн газар жижиг, дунд үйлдвэрлэл дэмжих бодлого баримталж эхлэн, АНУ болон БНХАУ хоорондын худалдааны маргаан зэрэг нь БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд унах гол шалтгаан болжээ.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,340.13	0.26% ▼
Dow Jones	АНУ	22,445.37	-6.87% ▼
S&P 500	АНУ	2,416.62	-7.05% ▼
Nasdaq	АНУ	6,332.99	-8.36% ▼
S&P/TSX	Канад	13,935.44	-4.52% ▼
FTSE 100	Их Британи	6,721.17	-1.81% ▼
S&P/ASX 200	Австрали	5,467.60	-2.40% ▼
Nikkei 225	Япон	20,166.19	-5.65% ▼
Hang Seng	Хонг Конг	25,753.42	-1.31% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	107.29
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	95.18
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	94.28
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	110.51
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.78
DBM' 2023	USD	7.250%	98.06
TDBM' 2020	USD	9.375%	104.19

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.500	0.04 ▲
Libor 3M	2.820	0.02 ▲
Libor 6M	2.900	0.00 ▲
Libor 1YR	3.070	-0.02 ▼
US 2YR Bond	2.639	-0.10 ▼
US 3YR Bond	2.619	-0.11 ▼
US 5YR Bond	2.639	-0.09 ▼
US 10YR Bond	2.790	-0.10 ▼

Валютын ханш /төг/

Валют	2018.12.21	Өөрчлөлт
USD	2,638.03	0.12% ▲
CNY	382.45	0.06% ▲
EUR	3,025.56	1.10% ▲
RUB	38.83	-2.14% ▼
KRW	2.36	1.29% ▲
JPY	23.71	2.20% ▲
CAD	1,953.81	-0.76% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,263.81	2.03% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	14.71	0.62% ▲
Зэс	USD/lb.	267.50	-2.87% ▼
Нүүрс	USD/MT	102.30	-0.49% ▼
WTI газрын тос	USD/bbl.	46.06	-10.23% ▼
Brent газрын тос	USD/bbl.	54.37	-9.92% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	3.79	4.41% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. X	6.30%
Бодлогын хүү	2018. XI	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. X	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. X	12.30%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. X	5.40%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. X	17.40%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. X	10.70%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 39 компанийн 2,806.0 сая төгрөгийн 11,357,815 ширхэг хувьцаа арилжигдав.


“Жинст-Увс” /JIV/ компанийн хувьцаа 13.71%-аар буюу хамгийн ихээр өсч 1,991 төгрөгт хүрч хаагдсан бол “Нако түлш” /NKT/ компанийн хувьцаа 36.41%-аар буурч 109.7 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны зах зээл дээр нийт 8,224 ширхэг үнэт цаас 847.2 сая төгрөгөөр арилжаалагдсан байна.


12-р сарын 21-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,405.7 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,340.13 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.26%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	2,806.0
Зах зээлийн үнэлгээ	2405,706.4

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,340.13	0.26% ▼
MSE I индекс	9,752.75	0.18% ▲
MSE II индекс	8,712.95	0.64% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Нако түлш	7,588,685	832,481,753
Говь	901,391	326,536,619
АПУ	354,807	216,346,868
Мандал даатгал	24,614	128,214,240
Ард даатгал	159,956	118,948,377

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Жинст-Увс	1,991.00	13.71% ▲
Женко тур бюро	75.00	13.64% ▲
Бөхөг	3,000.00	11.11% ▲
Шарын гол	2,130.00	4.41% ▲
Эрдэнэ ресурс девелопмент корп.	582.00	3.93% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Нако түлш	109.70	-36.41% ▼
Мон-Ит булигаар	7,500.00	-14.77% ▼
Ремикон	29.00	-14.71% ▼
Тав	10,000.00	-13.79% ▼
Их барилга	3,100.00	-11.40% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Мирэ Эссет Секьюритис Монгол	3,285,037,086
Ард капитал групп	1,778,450,756
Голомт капитал	504,984,262
Ард секьюритиз	404,353,387
Бумбат-Алтай	303,010,073

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	610.50	649,683
Таван толгой	7,130.00	375,503
Говь	353.41	275,700
МИК	10,300.00	213,306
Сүү	212.00	72,928

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-01/08/19-A0285-13.745	140	14,135,800	100,970	100,970	104	13.745%
2	ZGEB-BD-15/08/20-A0295-14.5	1,097	113,660,170	103,610	103,610	156	14.500%
3	ZGEB-BD-15/08/20-A0295-14.5	514	51,400,000	100,000	100,000	156	14.500%
4	ZGEB-BD-18/07/20-A0275-15.14	3,920	409,091,200	104,360	104,360	156	15.140%
5	ZGEB-BD-24/10/19-A0348-13.955	1,253	127,166,970	101,490	101,490	104	13.955%
6	ZGEB-BD-26/09/19-A0326-13.955	1,300	131,755,000	101,350	101,350	104	13.955%

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.08.31	2018.09.10	2018.10.10-нд олгов
2	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
3	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
4	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов
5	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с
6	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов
7	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
8	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор
9	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
10	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
11	SUL	Жуулчин дюти фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
12	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
13	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
14	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов
15	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
16	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов
17	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор
18	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов
19	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов
20	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
21	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
22	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	2018.03.06	2018.09.21-нд олгов
23	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов
24	TAH	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
25	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с
26	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов
27	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Баян-Алдар” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Баян-Алдар” ХК нь 2018 оны 10-р сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаараа “Монгорүматрикс Гинко” ХХК-тай нэгдэхээр шийдвэрлэсэн байна.

Үүнтэй холбогдуулан энэхүү асуудлын эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.1-д заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрх үүслээ.

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах хүсэлтийг хүлээн авч эхлэх огноо: 2018 оны 12-р сарын 24-ны өдөр

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх дуусах огноо: 2019 оны 2-р сарын 4-ний өдөр

Шаардах эрхийг хэрэгжүүлэх нэгж хувьцааны үнэ: 642 төгрөг
Шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй бол “Баян-Алдар” ХК болон харилцдаг үнэт цаасны компанид хандана уу.

Шаардах эрх хэрэгжүүлэгч “Баян-Алдар” ХК: УБ, ЧД, 1-р хороо Аризона төв 12 тоот.

Холбогдох утас: 7011-3980, 8800-8702

Мөн СЗХ-ны 2018 оны 12-р сарын 14-ний өдрийн хуралдаанаар тус компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөнтэй холбогдуулан Улсын байцаагчийн 2018 оны 12-р сарын 17-ны өдрийн 59 тоот албан шаардлагаар тус компанийн үнэт цаасны арилжааг 2018 оны 12-р сарын 17-ны өдрөөс эхлэн түр зогсоолоо.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зарим компанийн үнэт цаасыг бүртгэлээс хаслаа

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Дархан мах экспо” ХК, “Эвлэл” ХК, “Ажлын хувцас” ХК-ууд нь татан буугдсан болох нь баримтаар тогтоогдсон, “АЗАН” ХК нь Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны бүртгэлд бүртгэгдээгүй, “Бэрэн майнинг” ХК нь үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрч бүртгэснээс хойш зургаан сарын дотор тухайн үнэт цаасыг анхдагч зах зээлд гаргаагүй байх тул “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 12-р сарын 19-ний өдрийн А/139 тоот тушаалаар тус компаниудыг Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн жагсаалтаас хаслаа.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Эрдэнэ ресурс корпорэйшн” хөндий алтны төслийн анхан шатны эдийн засгийн тооцооллыг танилцууллаа

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” (TSX: ERD | MSE: ERDN) нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт орших өөрийн 100% эзэмшлийн Хөндий алтны төслийн анхан шатны бөгөөд хөндлөнгийн эдийн засгийн тооцооллыг (“PEA”) RPMGlobal Ltd (Хонг Конг) компаниар NI 43-101 эрдсийн нөөцийн тайлагналын стандартын дагуу боловсруулж олон нийтэд танилцуулсан байна.

Компани цаашид ашиглалтын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахаар төлөвлөж байгаа бөгөөд үүний хажуугаар урьдчилсан ТЭЗҮ боловсруулах, 2019 оны эхээр уурхайн барилга байгууламж байгуулах, холбогдох бусад зөвшөөрөл авах ажлууд төлөвлөгдөж байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

2018 онд IPO гаргасан дүнгээр Хонгконгийн Хөрөнгийн бирж тэргүүлэв

2018 онд IPO гаргасан дүнгээр Хонгконгийн Хөрөнгийн бирж тэргүүлж байна. Тус биржид нийт 35.7 тэрбум ам.долларын IPO хийгдсэн нь Нью-Йоркийн Хөрөнгийн биржийг давсан үзүүлэлт болжээ.

Хэдий тийм боловч Хонгконгийн Хөрөнгийн биржид хувьцаагаа арилжаалж эхэлсэн эхний сардаа 100 сая ам.доллараас дээш хөрөнгө босгосон компаниудын тоо 6.2 хувиар буурсан байна. Энэ нь 2008 оноос хойших хамгийн тааруу дүн болжээ. Салбараар нь харвал технологи, интернет, биотехнологийн салбарын компаниудын IPO гаргасан тоо жилийн өмнөхөөс хоёр дахин нэмэгдэж, 40 хувьд хүрсэн байна. Хэдий тийм боловч “MSCI Hongkong” индекст технологийн компаниудын хувьцааны ханш хамгийн их уналттай байгаа аж. Тухайлбал, 5-р сараас хувьцаагаа арилжаалж эхэлсэн “Ping An Healthcare”, “Technology Co” болон 8-р сард IPO гаргасан “Ascleptis Pharma” компаниудын хувьцааны ханш 43-57 хувиар унасан бөгөөд улмаар энэ оны хамгийн тааруу арилжаалагдаж байгаа хувьцаануудаар нэрлэгдэж байна.

7-р сард ухаалаг гар утас үйлдвэрлэгч “Xiaomi” компани хувьцаагаа арилжаалж эхлэн, үнэлгээ нь 50 тэрбум ам.доллараар хэмжигдэх болжээ. Гэсэн ч энэ нь тус компанийн удирдлагын таамгаас хоёр дахин доогуур дүн болсон юм.

Эх сурвалж: BloombergTv.mn



Хөрөнгийн зах зээлийн шилдгүүдийг тодрууллаа

Монголын хөрөнгийн зах зээлийн шилдгүүдийг тодруулдаг “GRAND BULL AWARDS 2018” ёслол хүндэтгэлийн арга хэмжээг Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооноос санаачлан “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК, “Монголын Үнэт Цаасны Бирж” ХХК, “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК, “Арилжааны Төлбөр Тооцоо” ХХК-иудтай хамтран 2018 оны 12-р сарын 13-ны өдөр амжилттай зохион байгууллаа.

Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдын өнгөрсөн дөрвөн жилд үзүүлсэн ололт, амжилтыг дүгнэн, номинаци тус бүрт нэр дэвшсэн шилдэг таван байгууллага/мэргэжилтэн/-с дараах шилдгийн шилдгүүдийг тодруулан “GRAND BULL AWARDS 2018” цомыг гардууллаа.

“GRAND BULL AWARDS 2018”-ийн номинаци тус бүрийн шилдгийн шилдгүүдэд:

“Шилдэг брокерийн компани” - “БиДиСек ҮЦК” ХК;

“Шилдэг IPO” - “ЛэндМН ББСБ” ХК;

“Шилдэг хувьцаат компани” - “Говь ХК”;

“Шилдэг андеррайтерийн компани” - “БиДиСек ҮЦК” ХК;

“Шилдэг мэргэжилтэн” - Б.Өлзийбаяр /“Ард капитал ҮЦК”-ийн Гүйцэтгэх захирал, Монголын арилжаа эрхлэгчдийн холбооны Удирдах зөвлөлийн дарга/ тус тус шалгарлаа.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

УУХҮЯ: 2018 онд БНХАУ-ын “Зон Хэн Юу Тиан” компани туршилтаар 246 тонн газрын тос экспортолсон

2018 онд газрын тосны хайгуулын ажил ихээр явагдсан билээ. 12-р сарын байдлаар нийт хайгуулын 25 талбайд 26 бүтээгдэхүүн хуваах гэрээ хүчин төгөлдөр байгаа талаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээллээ.

Үүнээс гурван талбайд олборлолт, 17 талбайд хайгуул хийж байгаа бол нэг талбайд Австралийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Elixir Petroleum” компани Монгол дахь “Golden Horde” компаниар дамжуулан нүүрсний давхаргын метан хийн хайгуул хийж эхлэх гэж байна. Мөн таван талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээ дуусгавар болох гэж байгаа талаар Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээллээ. 2018 онд Эргэл XII талбайд “Смарт ойл Монголиа” компани чичирхийллийн урьдчилсан судалгаа хийсэн аж. Мөн Арбулаг ХХИХ талбайд “Макс ойл” компани, Онги V, Богд IV талбайд “Капкорп Монголиа” ХХК цооног өрөмджээ.

Харин Галба XI талбайд “Зон Хэн Юу Тиан” компани туршилтаар олборлолт хийж, 246 тонн газрын тос экспортолжээ. 12-р сарын 12-ны байдлаар нийт зургаан сая баррель буюу 814.5 мянган тонн газрын тосыг Монгол Улс экспортлоод байна. 9-р сарын сүүлчээр бүрэн зогсоогоод байсан “Петрочайна Дачин тамсаг” компанийн тээвэр эргэн сэргэсэн гэдгийг Уул уурхай, Хүнд үйлдвэрийн сайд мэдэгдлээ.

Хайгуул идэвхжиж байгаатай зэрэгцээд газрын тосны үйлдвэр байгуулах ажил үргэлжилж байна. 12-р сарын 6-нд төмөр замын дэд бүтцийн ажлыг эхэлжээ. Ерөнхийдөө нийт дэд бүтцийн ажил нь 50 хувийн гүйцэтгэлтэй байна. Барилгын ажлыг одоо түр завсарлаад 3-р сараас дахин эхэлж, ирэх оны III улиралд дуусгахаар зорьж байна. Мөн үйлдвэрээс гарах нэг литр бүтээгдэхүүний дундаж өртөг 0.348 ам.доллар буюу 850 орчим төгрөг болохоор тооцож байгаа аж. Харин зах зээлд гаргах үнийг Засгийн газар тогтооно гэж Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

ҮСХ: Махны экспорт оны эхний 11 сард 62.9 хувиар өсөж, 69.9 сая ам.доллар хүрээд байна

2018 оны эхний 11 сард хонь, ямаа, үхэр, адууны махны экспортын дүн 70 орчим сая ам.долларт хүрээд байгааг Үндэсний статистикийн хороо мэдээллээ. Энэ нь махны экспорт өмнөх оны мөн үеэс 62.9 хувиар, 2016 оны эхний 11 сартай харьцуулахад тав дахин өссөн үзүүлэлт болж байгаа юм.

Энэ дундаас хонь, ямааны махны экспорт хамгийн их хэмжээгээр буюу хоёр жилийн хугацаанд 36 дахин өсжээ. Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн дэд сайд Ж.Саулегийн мэдээлснээр мал сүргийн бүтцэд бог давамгайлж, хонин сүрэг нийт малын 45.4 хувь, ямаа 41.2 хувийг тус тус эзэлж байна. Энэ нь эргээд зохистой бүтцийг алдагдуулж, бэлчээр доройтох, даац хэтрэх, улмаар мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн чадавх, бүтээмжийг бууруулах шууд хүчин зүйл болж байна гэж салбарынхан үзэж байна. Тиймээс бэлчээрийн даац, сүргийн эргэлтийг харгалзаж жилд 180 орчим мянган тонн мах экспортлох боломжит нөөц байгааг онцоллоо.

Мөн “Finance Forum 2018”-ийн үеэр эдийн засагчид Монголын экспорт төрөлжиж байгааг дурдаж байсан юм. Өөрөөр хэлбэл хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж байгааг онцоллоо.

Эх сурвалж: BloombergTv.mn

Алтны ханшийн 2019 оны төлөв

Олон улсын зах зээлд худалдааны маргаанаас улбаалсан эрсдэл байгаа ч хөрөнгө оруулалтын аюулгүй хэрэгсэл гэгддэг алтны ханш энэ онд төдийлөн өсөлгүй, тав орчим хувиар буураад байна.

Ийнхүү буурахад ам.долларын ханш чангарсан нь голлон нөлөөлсөн гэдэгтэй дийлэнх шинжээчид санал нэг байна. “Bloomberg Intelligence”-ийн судалгаагаар ам.долларын ханш чангарахад нөлөөлсөн гол хүчин зүйл нь Холбооны Нөөцийн банкны бодлого ажээ. Мөн БНХАУ юанийн ханшийг доогуур барих шууд бус аргачлал хэрэглэж байгаа нь ам.доллар өндөр тогтоход нөлөөлж байна гэж дүгнэжээ. “Bloomberg”-ийн судалгаанд оролцсон шинжээчид энэ онд Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ нэмэх магадлал 77 хувьтай гэж дүгнэсэн байна. Энэ нь шар металлын ханш ирэх оны эхээр сулрах магадлалыг нэмэгдүүлж байгаа ажээ.

Нөгөө талаас улс төрийн гэнэтийн шийдвэрийн нөлөөнд олон улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ унаж болзошгүй байна. Ийм тохиолдолд тэргүүлэх гүрнүүдийн эдийн засагт нөлөөлж болзошгүй тул хөрөнгө оруулагчид Засгийн газрын бонд гэхээс илүүтэй алтанд хөрөнгө оруулах магадлал өндөртэй байгаа аж. Энэ нь шар металлын үнэлгээг өсгөнө гэж “Bloomberg”-ийн шинжээчид тооцож байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



“Тавантолгой түлш” компани 8088 тонн сайжруулсан түлш нөөцөлжээ

Шахмал түлшний үйлдвэр байгуулахад шаардагдах хөрөнгийг “Эрдэнэс Тавантолгой” компани гаргана гэж Засгийн газар мэдээллээ. Улаанбаатар хотын сайжруулсан шахмал түлшний жилийн хэрэглээ 600 мянган тонн гэж тооцоолж байгаа аж.

“Тавантолгой түлш” компани ирэх оны 9-р сарын 15 хүртэл 600 мянган тонн түлш нөөцлөх бөгөөд одоогоор нийт 8,088 тонныг нөөцөлсөн гэж Засгийн газар мэдээлсэн юм. Засгийн газрын хуралдаанаар шахмал түлшний нөөц бүрдүүлэх, сайжруулсан түлшний чанарыг олон улсын стандартад хүргэх зорилгоор нүүрс гүн боловсруулах дэвшилтэт техник, технологи, тоног төхөөрөмж суурилуулахыг даалгасан байна. Ирэх оны 5-р сараас нийслэлд түүхий нүүрс оруулахгүй байх шийдвэр гарсан бөгөөд энэ хүрээнд нийслэлийн өрхийн түлшний хэрэгцээг шахмал түлшээр хангах зорилттой байгаа юм. Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд одоогоор Сонгинохайрхан дүүргийн найман хорооны 26 мянга гаруй өрхөд 80 мянган тонн сайжруулсан түлш нийлүүлэх зургаан аж ахуйн нэгж ажлаа эхэлсэн байна. Ингэснээр түүхий нүүрсний хэрэглээг 150 мянган тонноор, PM2.5-ыг 150-аар бууруулна гэж Засгийн газар мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

Том төслүүд, эдийн засгийн төрөлжилт ба төлбөрийн тэнцэл

2018 оны эхний 11 сарын байдлаар худалдааны тэнцэл ашигтай, төлбөрийн тэнцлийн алдагдал бага байгаа нь төгрөгийн ханш тогтворжих суурь болж байна гэж Монголбанк мэдээллээ. Хэдий тийм боловч төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.1 дахин өсөөд байна.

Оны эхнээс төгрөгийн ханш 8.3 хувиар сулраад байгаа аж. Урсгал дансны алдагдал 1.3 тэрбум ам.доллараас 365 сая ам.долларыг зөвхөн тээврийн үйлчилгээний зардалд зарцуулж байна гэж Төв банк мэдээллээ. Энэ оны хувьд нүүрсний тээвэр эрчимжиж түүхэн дээд хэмжээнд хүрэх магадлалтай байна. Засгийн газраас төмөр зам зэрэг том төслүүдээ хөдөлгөх, эдийн засгийг төрөлжүүлэх зэрэг суурь асуудлуудаа шийдвэл төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах боломжтой гэж Монголбанк онцолсон юм.

Нөгөө талаас гадаад худалдааны ашиг мөн 2.1 дахин буурчээ. Гадаад худалдааны ашиг буурахад импорт оны эхнээс тасралтгүй 40 орчим хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Хэрэглээний зээл өмнөх оны мөн үеэс 26 хувиар өссөн нь импортыг нэмэгдүүлэх нэг шалтгаан болсон гэж Монголбанк үзжээ. Энэ хүрээнд хэрэглээний зээлийг хязгаарлах макро зохистой бодлогын арга хэмжээг ирэх сараас хэрэгжүүлнэ. Нөгөө талаас гадаад худалдааны бодлогыг хэрэгжүүлэх бие даасан бодлогын институц бий болгох шаардлагатай гэж зарим шинжээчид үзэж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

“Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд энэ онд олгохоор амласан санхүүжилтийн 1/3 орчим нь орж ирээд байна

“Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд 2018 онд 850 сая ам.долларын санхүүжилт Монголд орж ирэхээр төлөвлөсөн байсан ч одоогоор 300 сая гаруй ам.долларын санхүүжилт хийгдсэн гэж Монголбанк мэдээллээ.

Үүнээс Дэлхийн банк, Японы санхүүжилтийн дүн буурч, хойшилсон нь голлон нөлөөлжээ. “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” анх эхлэхэд Азийн хөгжлийн банк 900 сая ам.доллар, Олон Улсын Валютын Сан 425 сая ам.доллар, Дэлхийн банк 600 сая ам.доллар, Япон улс 850 сая ам.доллар, БНСУ 700 сая ам.долларын төслийн санхүүжилт хийхээ амлаж байсан юм. 2017-2019 онд БНХАУ-ын Төв банкны своп хэлцлээс гадна ойролцоогоор 2.8 тэрбум ам.долларын санхүүжилт олгохоор анх төлөвлөж байснаас одоогоор 30 гаруй хувь нь орж ирээд байна. 2017 оны мөн үед төлөвлөгдсөн санхүүжилтийн хэмжээ 90 хувь давж байсан бол энэ онд гүйцэтгэл бага байгаа юм.

Олон Улсын Валютын Сангаас “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн тав дахь шатны үнэлгээг хийж Монгол Улсад олгосон санхүүжилтийн дүн 217.33 сая ам.долларт хүрээд байна. Дэлхийн банкны санхүүжилт хүлээгдэхэд Олон Улсын Валютын Сангийн хөтөлбөр эхлэхэд анх тохирсон орлогын албан татварыг шатлалтай болгох, тэтгэврийн насыг нэмэгдүүлэх шийдвэрүүд биелээгүй нь голлон нөлөөлжээ. Япон улсын Засгийн газрын хувьд Дэлхийн банкны санхүүжилт хийгдсэний дараа санхүүжилтээ олгох хандлагатай байдаг байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



“Finance Forum 2018”-аар ирэх оны эдийн засгийн гол эрсдэлийг тодорхойлов

Ирэх онд төсвийн зардал, хөрөнгө оруулалт тэлж байгаа нь мөнгөний бодлогын орон зайг хумьж, улмаар чангаруулах нөлөөтэй гэж “Finance Forum 2018”-д оролцсон эдийн засагчид онцлолоо.

Тухайлбал, Дэлхийн банкны эдийн засагч Б.Даваадалай төсвийн хөрөнгө оруулалт импортыг өдөөх хандлагатай байгааг дурдаж байсан юм. Энэ оны эхнээс харвал импорт дунджаар 40 орчим хувийн өсөлттэй байна. Эдийн засгийн шинжилгээ, судалгааны төвийн Гүйцэтгэх захирал Г.Бумчимэгийн илтгэлд урсгал дансны алдагдал өсөх төлөвтэй байгааг анхааруулж байлаа. Урсгал дансны алдагдал 1.3 тэрбум ам.доллар хүрсний 300 сая ам.доллар нь тээврийн үйлчилгээний зардал байгаа учраас Засгийн газраас төмөр зам зэрэг томоохон бүтээн байгуулалт хийх нь төлбөрийн тэнцлийн дарамтыг бууруулна гэж Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эдийн засагч Б.Түвшинтөгс үзэж байна.

11-р сарын байдлаар төлбөрийн тэнцэл 51 сая ам.долларын алдагдалтай байгаа юм. Төлбөрийн тэнцлийн алдагдал буурсан ч урсгал дансны алдагдал өндөр хэвээр байгааг Олон Улсын Валютын Сан, Азийн Хөгжлийн банк зэрэг байгууллагууд анхааруулж байна 11-р сарын байдлаар Төв банк бодлогын хүүг нэг нэгж хувиар чангалж, 11 хувьд хүргэсэн юм. Мөн инфляци 11-р сарын дүнгээр улсын хэмжээнд 8.1 хувь болж өсөөд байна.

Ирэх онд бизнесийн орчинд ханшийн эрсдэл өндөр байна гэж “Finance Forum 2018”-д оролцсон зарим бизнесийн төлөөлөл хэллээ. Монголбанкны мэдээлснээр төгрөгийн ханш энэ онд ам.долларын эсрэг харьцангуй тогтвортой байсан ч сүүлийн саруудад суларсаар оны эцэст нийт 8.3 хувиар сулраад байгаа гэж онцлов. Үүнийг дагаад компаниудын долларжилт нэмэгдэх хандлагатай байгаа юм байна. Ам.долларын эрэлт өсөхөд дотоод хүчин зүйлээс гадна АНУ-ын Төв банкны бодлого чангарсан нь нөлөөлсөн гэдгийг хэлж байлаа. Ирэх онд төсөв талаас хөрөнгө оруулалтыг эрэмбэлэх, Төв банк талаас хүлээлтийг зөв удирдах ажлыг эрчимжүүлэх нь зүйтэй гэж Дэлхийн банк онцлолоо. Монголбанк ирэх онд хэрэглээний зээлийг бууруулах макро зохистой бодлогын арга хэмжээнүүдээ хэрэгжүүлж эхэлнэ. Мөн ханшийн эрсдэлээс сэргийлэхийн тулд валютын зээлийн эрсдэлийн жинг 150 хувь хүргэж өсгөхөөр шийдвэрлээд байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.